

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ**  
**“БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨР”-ИЙН ХҮРЭЭНД**  
**ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН**

2021.05.22

**Удирдлага зохион байгуулалтын талаар:**

Монгол Улсын Ойн тухай хууль болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу “Нэг өрх нэг мод” уриатайгаар мод тарих үйл ажиллагаа орон нутагт зохион байгуулсан.

Мод тарих уриалга, заавар, модны үрсэлгээ, худалдааны талаарх мэдээллийг байгууллагын facebook болон [www.baigal.gs.gov.mn](http://www.baigal.gs.gov.mn) цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлснээр өмнөх онтой харьцуулахад модны тоо, мод тарьсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тоо нэмэгдсэн.

1. Дэлхийн нийтээр тархсан цар тахалтай холбогдуулан хөл хорио, цээр тогтоосон үед иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг тарьц суулгацаар хангах зорилгоор мод бутны үзэсгэлэн худалдааг цахим хэлбэрээр буюу үнийн саналыг иргэд болон, аж ахуйн нэгж, байгууллагад мэдээлэл өгч, олон хүн цуглуулахгүйгээр, халдвар хамгааллын дэглэм баримтлан зохион байгуулан ажилласан. Орон нутагтаа мод үржүүлдэг 1 иргэн, 2 ААНБ-тай хамтран 21 төрлийн 4600 гаруй мод, бутар ханган ажиллалаа.

Монгол улсын ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигаар жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн “Бямба” гарагийг “МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨР” болгон зарласан байдаг бөгөөд мод тарих үндэсний өдөртэй 33 дахь орон болж байсан билээ. Мод тарих хүсэл сонирхолтой иргэн, аж ахуйн нэгж байгууллага Цэргийн алдар хөшөө, авто замын дагуу ойн зурваст мод тарих боломжтой.

Мод тарих хуваарь	
1	5 дугаар сарын 08-ны өдөр
2	5 дугаар сарын 09-ны өдөр



**Аймгийн төв-Сүмбэр сум:**

2. Мод тарьсан байдал:

- 🌱 Улсын чанартай А0101 авто замын дагуу ойн зурвасын нөхөн тарилтад 20 аж ахуйн нэгж байгууллагын 230 гаруй албан хаагч 690 ширхэг мод, сөөг
- 🌱 Сүмбэр сумын 3-р баг “Цэргийн алдар хөшөө” цогцолборт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд 90 ширхэг улиас
- 🌱 Иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн өмчлөл, эзэмшил болон нийтийн эзэмшлийн хариуцсан талбайд 3420 ширхэг мод тус тус тарьсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 01 сарын 29-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар орон нутагт эрх шилжсэн 50.0 сая төгрөгийн санхүүжилттэй “Цөлжилт газрын доройтолд өртсөн газрыг бууруулах зорилгоор 25 га талбайд хамгаалалтын хашаа барьж, мод бут тарих” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ойн зурвасын хамгаалалтын

хашаа байгуулж, усалгааны шугам хоолой татах ажлыг “Жавхлант арвижих ХХК”, 1200 мод тарих ажлыг Батбадрах дэлгэр ХХК гүйцэтгэж байна. Сүмбэр сумын 4 дүгээр багт шинээр бий болж буй 25 га талбайд 1225 ширхэг мод бут тарьсан. Ажлын гүйцэтгэлийн явц 70 хувьтай.

#### **Шивээговь сум:**

🌱 Иргэн, аж ахуйн нэгж байгууллага өөрийн өмчлөл, эзэмшил, хариуцуулсан нийтийн эзэмшлийн хашаандаа хайлаас 205, сухай 10, улиас 163, чацаргана 68, нийт 446 мод, бут тарьсан байна.

🌱 Даян Дэлхийн Байгаль орчны сангийн жижиг төсөл, хөтөлбөрийн Энх Агуулга сангийн хэрэгжүүлж буй “ Иргэдийн оролцоотой Ногоон сумын бий болгох” төслийн хүрээнд суманд 34 иргэнд 200 хайлаас, 100 улиас, 65 бургас, 45 чацаргана, 45 үхрийн нүд, 45 бөөрөлзгөнө, нийт 500 мод, бут тарьсан.

#### **Баянтал сум:**

🌱 Даян Дэлхийн Байгаль орчны сангийн жижиг төсөл, хөтөлбөрийн Энх Агуулга сангийн хэрэгжүүлж буй “ Иргэдийн оролцоотой Ногоон сумын бий болгох” төслийн хүрээнд суманд 34 иргэнд 200 хайлаас, 100 улиас, 65 бургас, 45 чацаргана, 45 үхрийн нүд, 45 бөөрөлзгөнө, нийт 500 мод, бут тарьсан

🌱 **Аймгийн хэмжээнд нийт:** 34 аж ахуйн нэгж байгууллагын 290 гаруй албан хаагч, 350 гаруй иргэн 6871 ширхэг мод бутыг тарьсан байна.

#### **Бусад үйл ажиллагаа:**

Авто зам дагуух 2014-2017, 2019, 2020 оны хооронд байгуулсан ойн зурвасын мод бутанд нөхөн тарилт хийсэн. Аж ахуйн нэгж байгууллагууд нь бүх нийтийн мод тарилтанд идэвх санаачлагатай, албан хаагчдыг бүрэн хамруулан оролцож, байгууллагууд хариуцсан талбайдаа шинээр болон нөхөн тарьж, ойн зурвасын хамгаалалтын хашааг засаж, модны тогоог сэргээж, хог хаягдлыг түүж цэвэрлэсэн.

Тайлан хянасан: БОАЖГ-ын дарга

Д.Мөнх-Эрдэнэ

Тайлан бичсэн: БОАЖГ-ын мэргэжилтэн

Т.Дашцэдэн

**“БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨР”-ИЙН ХҮРЭЭНД ГОВЬСҮМБЭР АЙМАГТ  
ТАРЬСАН МОДНЫ ДҮН МЭДЭЭ**

2021.05.22

Чойр хот


Сумын нэр	Өрхийн тарьсан модны тоо		Аж ахуйн, байгууллагын тарьсан модны тоо			Баг хороонд шинээр байгуулсан бичил, цэцэрлэг			Зүлэгжүүлэлт хийсэн талбай м <sup>2</sup>	Байгуулсан цэцгийн мандал м <sup>2</sup>	Таригдсан модны тоо		Нийт таригдсан модны тоо	Мод тарьсан иргэдийн тоо	Мод тарьсан аж ахуйн нэг байгууллагын тоо	Нийт зарцуулан зардлын тооцоо, ₮
	Хашаандаа тарьсан модны тоо	Мод тарьсан өрхийн тоо	Орчин тойрон, бичил цэцэрлэг, сад, цэцэрлэгт хүрээлэнд тарьсан модны тоо	Нэрэмжит ой, төгөлд		Шинээр байгуулсан бичил цэцэрлэгийн тоо	Талбайн хэмжээ га	Тарьсан модны тоо			Модны тоо	Бут сөөгний тоо				
				Байгуулагдсан нэрэмжит төгөл,	Таригдсан модны тоо											
Сүмбэр	2320	150	1100	35.6	780	1	2	1225	-	-	790	4635	5425	290	25	Иргэн, ААНБ өөрийн хөрөнгөөр
Шивээговь	500	34	446	-	-	-	-	-	-	-	263	683	946	81	9	Иргэн, ААНБ өөрийн хөрөнгөөр
Баянтал	500	40	-	-	-	-	-	-	-	-	100	400	500	50	3	Иргэн, ААНБ өөрийн хөрөнгөөр
Нийт	3320	224	1546	-	-	-	-	-	-	-	1153	5503	6871	421	37	-

Тайлбар: Цөлжилт газрын доройтолд өртсөн газрыг бууруулах хүрээнд 25 га талбайд 1200 ширхэг мод бут тарих ажлыг БОАЖЯ-ны санхүүжилтээр, 5671 ширхэг мод бутыг иргэн, аж ахуй нэгж, байгууллага өөрийн зардлаар тарьсан байна.

МЭДЭЭГ НЭГТГЭСЭН: БОАЖГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Т.ДАШЦЭДЭН

## Мод бутны худалдаа



Ойн зурваст мод тарьж буй байдал





Нийтийн эзэмшлийн талбайд иргэд мод тарьж буй байдал



**Цөлжилт газрын доройтолд өртсөн газрыг бууруулах зорилгоор мод тарих ажлын явц**

